



Дурсамж

СЭТГЭЛД УЯАТАЙ ДАРХАН ХИЛ

Ард түмний дунд "Азийн Арвай" хэмээн алдаршсан Арвай генералын амьдралын дөч гаруй жилийн түүх хилийн цэрэгтэй салшгүй холбоотой. "Эгэл хилчдийн ээдрээт замын сургамж", "Монгол Улсын хил хамгаалах салбарын алба-байлдааны бэлэн байдал" зэрэг ном зохиол туурвиж олны хүртээл болгосон, Цэргийн Шинжлэх Ухааны дэд доктор, профессор, дэслэгч генерал Ш.Арвай гуай эдүгээ ХЦДС-ийн эрдэм шинжилгээний төвд тэргүүлэх ажилтнаар ажиллахын сацуу эрдмийн ажлаа туурвиж чөлөө завгүй хөдөлмөрлөсөөр сууна.

Жирийн хилчин байлдагчаас НАХЯ-ны орлогч сайд, Хилийн цэргийн командлагч хүртэл алба хаасан энэ хүний яриа хөөрөө өнөөгийн хилчдэд сонирхолтой, бас сургамжтай байх болов уу хэмээн түүнтэй хийсэн ярилцлагыг нийтэлж байна.

Сурв- Генерал Арвай гэхээр хилчид төдийгүй ард түмэн андахгүй мэднэ. Таны хилчин болсон амьдралын зам анх яаж эхэлсэн бэ?

Ш.А-Би Дорноговийн Эрдэнэ сумын уугуул иргэн. Тэгэхлээр хилийн аймаг, хилийн сумын хүн. Манайх удмаараа хилчин. Өвөөгийн минь Лувсанцэрэн гэдэг байв. Тэр хүн насаараа улсын хилийн аюулгүй байдалд зүтгэсэн юмдаа. Эмээтэйгээ Замын-Үүдийн отрядын дэргэд бага наснаасаа хамт байсан. Эмээ, ээж хоёр отрядод аргал түлээ түүж өгнө. Хааяа сүү тараг таньдаг даргындаа хүргэж өгнө. Би дагаад л явна. Отряд гэж сайхаан сайхан. Дарга нарын байранд эрээн будагтай олон сайхан гэртэй. Бас байшинтай. Тэр үед байшин гэж мэдэх биш. Манай гэр яахав дээ, өвөл зунгүй дан бүрээстэй. Шөнө унтахдаа дээврийнхээ цоорхойгоор од тоолсоор байгаад нэг мэдэхэд унтчихдаг байв. Отрядынхонтой бол харьцуулах юмгүй. Би отрядод анх удаагаа кино гэдэг юм үзсэн. Тэнд оросын нэгэн хилчин шархдахад морь нь

эзнээ эргэсээр байгааад амийг нь авардаг. Мөн морин сургууль хийхийг үзэж биширч явлаа. Сайхан хувцастай, сэлэм зүүсэн дарга нарын алхах гишгэх нь, дуугарах нь хүртэл сүртэй. Түргэн том болж эд нар шиг болох юмсан гэж өөрийн эрхгүй сэтгэл дэвлэлдэг юм билээ. Тэр л хөтөлсөн байх. 1958 онд цэрэгт мордлоо.

Тэр үед Батлан Хамгаалах Яам, НАХЯ нэг байсан юм билээ. Улаанхуаранд нэг сар цэргийн албанд зүгшээд л. Дараа нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот руу хилчин болохоор мордсон доо. Одоо 43 жил энэ албанд зүтгэж явна. Хилчин гэдэг дэндүү их эрсдэлтэй, тэгсэн атлаа даанч сайхан алба даа. Нас ахих тутам л хилээ, хилчнээ хайрлаад, учрыг нь ухах, ахих тутам үнэ цэнэ нь улам их тодроод л байдаг эн зэрэгцэхийн аргагүй бахархмаар сайхан алба шүү дээ. Ер нь жинхэнэ эр хүн чинь хилээс төрдөг юм даа.

Сурв-Таны анх алба хааж байсан хилийн цэрэг, өнөөгийн хилийн цэрэг хоёрын хооронд мэдээж их ялгаа байж таарна. Энэ талаар та юу хэлэх вэ?

Ш.А-Ялгаа байлгүй яахав. Юм бүхэн цаг үетэй. Өнгөрсөн зуун бол XX зуун. Өөрийн үетэй, орчинтой. Миний алба хаасан жилүүдийг ч дотор нь хуваахад гурван үе тодроод байдаг. Би хилийн цэргийг татан буулгасны дараахан үед энэ албанд ирсэн хүн. Эх орны чөлөөлөх дайны явц дунд хоёр хөрш харилцан тохиролцсоноор Хятад улс манай улсыг дайны дараа одоо байгаа хилээр нь хүлээн зөвшөөрнө гэж амлалт өгч баталгаажуулсан байв. Гэтэл хилийн цэргийг дайн дууссаны хойно татан буулгасан нь их харамсалтай явдал болсон. Би жам ёсоороо хилийн цэрэг дахин сэргэж амьсгал эхэлсэн үед цэрэгт ирсэн юм. Энэ бол нэг үе. Хоёрдахь үе нь улсад нөмөрсөн аюулаас сэргийлэх, улс орныхоо дархан хил хязгаарыг хамгаалах сорилтын жилүүд байв. Энэ бол 1960-1990-ээд он шүү дээ. Энэ үед дэлхийд социалист, капиталист хоёр эсрэг тэсрэг системийн хоорондын зөрчил хурцдаж, дэлхий халуун цөмийн дайны ирмэгт тулж очсон жилүүд байсан. Нөгөө талаар хөрш хоёр их гүрний удирдлага дэлхийд ноёлох байр сууриа хадгалахын төлөө явуулсан тэмцлийн улмаас бие биений эсрэг улс орноо дайны байдалд оруулах хүртэл байдал хурцадсан үед завсар нь орших манай улсын хувьд маш эгзэгтэй үе тулгарсан юм. Энэ үед улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын чанар сул байснаас ямар уршигт хүрч болох нь хэнд ч ойлгомжтой байлаа шүү дээ. Энэ үеийн хилчид дэндүү өндөр ачаалалтай үүргээ гүйцэтгэсэн. Яагаад гэвэл хилийн цэргээ орчин үеийн шаардлагад нийцсэн хэмжээнд цоо шинээр байгуулах, улсын

хилийг найдвартай хамгаалах хоёр үүрэг давхацсан юм. Гэвч манай алдарт хилчид эх орныхоо хилийг хамгаалах үүргийг нэр төртэй гүйцэтгэсэн. Гуравдахь үе нь дэлхийд дайны аюул холдож, энх тайван даяарчлах бүх нийтийн шинжтэй болсон үед хилийн цэрэг өвөрмөц үүрэг гүйцэтгэж байна. Харин хилийн цэргийн хувьд цоо шинэ, тэхдээ маш хариуцлагатай үе эхэллээ. Аливаа юм өөрийн хуультай, зүй тогтолтой. Тэрэнд захирагдахгүй бол алдаа гардаггүйг би дээр дурдсан. Тайван болсноор хилийн цэрэг хэрэггүй мэт, ер нь байсан ч ёс төдий байж болохоор зарим хүн төсөөлдөг. Гэтэл улсын хилийг манаж хамгаалж байгаа цэрэг бол харин алба-байлдааны бэлэн байдлын хувьд дээд зэргийн өндөр түвшинд байх зүй тогтолтой нь судалгаанаас харагддаг. Яагаад гэвэл хилийн зөрчил гаргуулахгүй байх талаар дорвитой арга хэмжээ авахгүй бол хэрэв хилийн зөрчил дахин давтагдаад байвал нөгөө аюул хүссэн ч, хүсээгүй ч дахиад л сэргэдэг, цэрэг зэвсэг хэрэглэхээс өөрөөр арилгах аргагүй болдог. Энэ үед улс төр-дипломатын арга гэж хичнээн хашгираад ч хэрэг болохгүй. Улсын хилийг зөрчинө гэдэг нэг улсын биш, хоёр улсын хилийг нэгэн зэрэг зөрчдөг, хоёр улсын аль алиных нь аюулгүй байдалд сэв суулгадаг, итгэлцэл, сайн хөршийн харьцааг эргэлзээтэй байдалд оруулдаг уршиг ихтэй хэрэг шүү дээ. Ялангуяа улсын хилийг олон улсын түвшинд баталгаажуулсан одоогийн нөхцөлд түүнийг зөрчих бололцоо олгоно гэдэг улс орны орших, эс оршихтой хүртэл холбогдоно. Тэгэхлээр өнөөгийн хил хамгаалалтын чанар, хилчдийн талаар бид дээр доргүй онцгой анхаарах ёстой. Харин хилчдийн хувьд хүлээх ёс суртахууны хариуцлага их тодорхой, өндөрт байлгүй болохгүй.

Сурв-Та НАХЯ-ны нэгдүгээр орлогч сайд, Х ба ДЦУЕГ-ын даргын албыг нэлээд жил хашсан. Хилийн отрядын дарга байгаад энэ том албыг хашихад танд ямар бэрхшээл тохиолдож байв?

Ш.А.- Юм бүхэн өөрийн орон зайтай. Отряд гэдэг улсын хилийн тодорхой хэсгийг манаж хамгаалдаг. Түүнийг хэрэгжүүлдэг хилийн заставуудтай, дээр нь удирдлага, хангалт үйлчилгээний тусгай салбаруудтай хилийн цэрэг гэдэг энэ том айлын нэг л гишүүн нь юм.

Хилийн цэргийн дарга гэдэг бол улсын 8163 км хилийг бүхэлд нь манаж хамгаалах албыг зохион байгуулж удирдах үүрэг хариуцлага хүлээдэг. Хилийн цэргээс гадна офицер улирагсдын гэр бүл үр хүүхэд, дээр нь хилд туслах хүчнийг оруулвал 100-аад мянган хүний хувь заяа энэ хүнтэй холбогддог. Бэрхшээлгүй алба гэж ерөөс хаа ч үгүй. Түүнийг давахад л хамгийн гол нь байгаа юм. Амт нь

эндээ байдаг. Бэрхшээл гэдэг бол үнэн чанартаа хийх ёстой боловч, хийгдэж чадаагүй байгаа тулгамдсан асуудал л юм шүү дээ. Хэрэв албыг урьдаас хэтийг нь хараад бодлого болгоод шийдвэрлэх арга замаа төлөвлөөд бэлтгэлээ сайн хангавал бэрхшээл гэж айгаад байх юм ерөөс байхгүй дээ. Отрядын даргын нэг онцлог бол улсаас өгсөн хүч хэрэгслийн боломжийг дээд зэргийн үр дүнтэй, ашигтай ашиглахад байдаг. Харин хилийн цэргийн командлагчийн хувьд үүнээс гадна улсын зүгээс хил хамгаалалт хилчдийнхээ алба, ахуй амьдралын талаар авах ёстой арга хэмжээг цаг тухайд нь төр засагт оруулж шийдвэрлүүлэн хэрэгжилтийг зохион байгуулах давхар үүрэг оногддог. Үүгээр л онцлог нь ялгагдана.

Сурв- Та энэ тухай тодорхой баримт дурдаж яривал сонин байх болов уу?

Ш.А.- Тэгье. Улсын хилийг найдвартай хамгаална гэдэг чинь мөн чанартаа улсын хилээ манах хамгаалах, хилийн цэрэг, түүний материаллаг баазыг бэхжүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа объектив хүчин зүйл, улсаас өгсөн хүч хэрэгслийн бүх боломжийг хилийн цэрэгт дээд зэргийн үр ашигтай ашиглах субъектив хүчин зүйлийн хоршсон үйл ажиллагааны үр дүн юм даа. Намайг хилийн цэргийн дарга байхад нам, төр засаг ялангуяа маршал Цэдэнбал хилийн хамгаалалт, хилчдийн талаар онцгой анхаарч байсан. Маршал улс төрийн товчоонд ажил үүргийн хуваариар хилийн цэргийг өөрөө хариуцдаг байлаа. Асуудлыг маш гүнзгий, тэхдээ онолынх нь хувьд учраас мэдэх, практикийн хувьд шийдэхгүй нэг ч асуудал үлдээхгүйг зарчим болгодог байв. Маршал Чойбалсан шийдвэрлэхгүй нэг ч асуудал хойш тавьж байгаагүй гэж ярьдагсан. Би улсын хилийн хамгаалалт, хилийн цэргийн талаар авах арга хэмжээг тав таван жилээр төлөвлөж аваад үндэслэлийг нарийн тооцоотойгоор газрын зураг дээр даргад, дараа нь Батлан хамгаалах зөвлөл дээр илтгэдэг байсан. Шийдээгүй буцаасан нэг ч асуудал байхгүй. Харин улам баяжуулж ул суурьтай шийдэж өгдөг байв. Тухайлбал Хилийн Цэргийн талаар авах арга хэмжээг улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх улсын таван жилийн төлөвлөгөөтэй уялдуулаад багцаар нь шийдвэрлэх ч юм уу, эсвэл гадаадаас авах зэвсэг, техникийн тусламжийг мөн л таван жилийн нэгдсэн захиалгад оруулаад тавьчихъя гэдэг байлаа. Маршалын нэг онцлог бол улсын хил, хязгаар нутагт байдал ямар байгааг, хил манадаг, хамгаалдаг хилчдийн амьдралын түвшин хэр зэрэг байгааг их нухацтай, онцгой анхаардаг байв. Нууц авдарнаас жижигхэн дэвтэр гаргаад, "За чи аажуухан яриарай. Би тэмдэглэж авна. Заримдаа

мартчих гээд байдаг боллоо" гэдэгсэн. Би ажил танилцуулахдаа яамны сайд, зөвлөхүүд, заримдаа улс төрийн газрын дурагтай хамт орно. Дарга, журам мэт захиргааны байгууллагын хэлтсийн эрхлэгч, орлогч эрхлэгчийн аль нэг, хилийн цэргийг хариуцсан референтийг заавал байлгана. Тэгээд тэдэнд тогтоол яаралтай бэлтгэ. Тэхдээ 1-2 хоногийн хугацаанд багтааж гарга гэж шаарддаг байсан юм. Надаас асуусан зүйлийг анхааралтай сонсож, зарим зүйлийг тэмдэглэж аваад "За тогтоолд ингэж тусга" гээд өөрөө санаагаа тодорхойлоод өгөх тохиолдол ч цөөнгүй. Би заримдаа халгаад нарийн ширийн юмыг тэр бүр хэлэхээс зовно. Гэтэл хэзээний гадарласан бололтой, зовох ичих хэрэггүй. Байдлыг яг байгаагаар нь яриарай гэнэ. Би цэргийн хүн учир босож зогсоод илтгэнэ. Гэтэл "Чи суу, суу!, сууж байгаад ярь" гэнэ. Тэр нь надад хамгийн хэцүү нь байсан. Тийм том хүний дэргэд цай уугаад даргад ном зааж байгаа юм шиг суугаагаар яриад дарга дэвтэртээ тэмдэглээд сууна гэдэг цэрэг хүний хувьд халгаатай харагдана биз дээ. Тэхдээ тэгж л байсан. Энэ бол хэн хэнийгээ хүндэтгэсний илрэлээс гадна хилийн алба гэдэг ямар их нэр хүндтэй алба болохыг л дарга надад ойлгуулж байна даа гэж би одоо ч гэсэн бодож явдаг. Дарга нэг удаа "Энэ хүнд үед чамаас хил хязгаарын амгалан байдал их шалтгаална шүү. Сайн ажиллаарай. Бид бүх бололцоог хангах талаар санаа тавина" гэж билээ. Би нэгэн удаа хилийн анги, салбараар яваад ирсэн үед дарга биднийг дуудаж надаас олон зүйл сонирхон, асуудал бүрийг шийдэж өгсөнийг санаж байна.

Сурё- Та түүнийгээ яриач. Уншигчдад сонин байх болов уу?

Ш.А- За тэгье л дээ. Дарга тэгэхэд хилээр сайд нар явж байна уу? Тэд ямар асуудлыг яаж шийдэж өгөв" гэж асуусан. "БХЯ-ны сайд Дорж гуай Сүхбаатар аймаг дахь отряддуудаар очсон. Өөр очсон сайд нар цөөхөн. Дагнаад шийдвэрлэсэн асуудал ч олонгүйдээ" гэхэд дарга, - Тийм байж болохгүй, хилийн хамгаалалт, хилийн цэргийн талаарх асуудлыг хамгийн тэргүүнд авч шийдвэрлэж байхыг бүх яаманд даалгаж сайд нарыг хилээр явж, шаардлагатай арга хэмжээ газар дээр нь шуурхай шийдвэрлэж өгөх заалтыг тогтоолд оруул гэв. - Хилчдийн хоол хүнс ямар байна?.

- Энэ талаар хангалттай. Харин хилчид шөнө алсад 10-12 цаг тасралтгүй үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл хүнсний норм нь өдрөөр бодогдоод, тэрнийгээ хэрэглэхээд албанд гардаг. Манаанд хэрэглэх хүнсний норм хэрэгтэй байгаа юм. - Алсад, шөнө удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэж байгаа хилчдэд нэмэгдэл хүнс өгье. Та нар бодоод тогтоолд тусгаарай. Хувцас нь ямар вэ дээ?

- Хувцас боломжтой байгаа. Харин морин дээр ардаа оноотой цагаан дээл, хөвөнтэй өмдний зах нь богино учир хилчдийг нуруунаас нь жиндүүлдэг нь ажиглагдсан.

- Дээлийнх нь хормойг уртасгая. өмдний захыг нь өндөрлөөд ар зоог нь таглаж байхаар хийе л дээ. Ер нь манай юм, хилийн албаны хэрэгцээ, хилчдийн онцлогт нь таарч байвал сайн. Гэхдээ цэрэгт нэг стандарт байдаг байгаа. Та нар саналаа тогтоолд хийгээрэй. Орон сууц ямар байна.

- Бид хилийн анги салбарыг иж бүрнээр нь барьж байгаа. Төвд ч ялгаагүй. Харин Улаанбаатарт байгаа офицер ахлагчдын орон сууцны асуудлыг шийдэхэд бэрхшээл байна. Бидний тооцоогоор эхний ээлжинд 450 орчим байр шаардлагатай байгаа юм.

- Бид аажимд нь төлөвлөгөөтэйгээр шийдье. Харин хоёр 60 айлын орон сууц гаргаж өгөхийг хотын гүйцэтгэх захиргаанд үүрэг болгон тогтоолд оруулъя гэснээ туслахдаа "Алив Содномыг надтай яриулчих" гэв. Удсангүй төлөвлөгөөний комиссын дарга Содном гуай дарга руу утасдав. Дарга "Содном оо! Би хилийн цэргийн талаар арга хэмжээ авч өгье. Чи хотод 60 айлын сууц нэгийг гаргаж өгөхийг бодооч" гэв. Содном гуай зөвшөөрөв бололтой. Дараа нь утсаа тавиад

- За энэ удаад 120 айлын сууц дээр 60 айл нэмэгдлээ. Бусдыг нь төлөвлөгөөнд тусгаад ээлж дугаартай бариулаарай. Хилээр явахад чамд өөр юу ажиглагдав.

- Хилчид 10 төгрөгийн цалинтай. Гэтэл оо, савангийн нормгүй, худалдаж авъя гэхэд мөнгө дутаад авч чадахгүй байна. Хилчид тамхи татах гээд туулайн баас, татсан тамхины хаягдал хүртэл түүж байхыг үзсэн.

- Саван, оо-ны нормтой болгохоор тогтоолд тусгая. Харин тамхийг... гэснээ улс төрийн газрын дарга генерал Дорж руу харсанаа надад хандаж та хоёр л аргалаарай гэв. Даргын шийдэж өгч чадаагүй асуудал ганцхан энэ л үлдсэн юм даа.

Сурь- Та хоёр ч отрядын даргаар ажилласан шүү дээ. Энэ үе танд мэдээж олон сайхан дурсамж үлдээсэн байж таарна. Товч боловч энэ үеийнхээ талаар ярихгүй юу?

Ш.А- Энэ хоёр отряд Монголд 2000 гаруй жилийн турш аюул учруулж байсан онцгой чиглэлд багтдаг. Үе үеийн алдарт хилчдийн цус хөлсөөр бий болсон дайчин түүхтэй отрядууд Дорноговийн чиглэлийн отряд нь дахин байгуулагдаж хөл дээрээ босч байсан учраас бэхжүүлэх чиглэлтэй ажилласан. Харин Халх голын отрядыг нэг жилийн хугацаанд шинээр барьж байгуулах, хилийг хамгаалах хоёр

үүрэг зэрэг оногдсон. Отрядын барьсан бодлогыг хүлээн авсан генерал Намсрайжав даргатай комисс, онц үнэлэлт өгч, хилчид та нар 3 жил хийгээд амжихгүй ажлыг нэг жилд багтаан хийжээ гэж дүгнэн баяр хүргэж байсан. Олон юм одоо ч хэвээр хэвээр байна лээ. Харин Сүндэв дарга тус ангийн захирагч байхдаа сургалтын сайхан төв байгуулсан байв. Дарга бол зохион байгуулагч, яг үнэнээр нь хэлвэл хилчдийн найдлага, зарц нь л юм шүү дээ. Харин хамаг ачааг хилчид маань л үүрдэг. Тэд гайхамшигтай идэвхитэй, бүтээлч, ухамсартай ажиллацгаасан. Би тэдэндээ л их баярлаж явдаг даа. Надтай хамт отрядоо байгуулсан, хамтран зүтгэсэн нөхөддөө аз жаргалыг хүсье. Олон юм одоо ч мартагдаагүй байна.

Сурв- Москвагийн хилийн цэргийн сургуульд манай олон үеийн хилчид сурч, зохих боловсрол эзэмшсэн. Энэ сургууль, багш нар, хамт суралцаж байсан нөхдийнхөө тухай та өнөөдөр юу ярих вэ?

Ш.А- Сурч боловсрох бололцоо нөхцөлөөр хангасан эх орон ард түмэндээ насан туршдаа баярлаж явдаг. Ард түмнийхээ итгэлийг дааж ачийг нь хариулсан гэж өөрөөрөө бахархах бүрэн эрхтэй болсон найз нөхөддөө, буурал анд нартаа энэ ялдамд баяр хүргэе. Тэд амьдрал албаны хүнд шалгуурыг туулж давж гараад ихэнх нь гавьяаныхаа амралтыг эдэлж яваа. Насан туршдаа эдэлж баршгүй ухаан суулгаж, эрдмээр зэвсэглэсэн багш нартаа баярлалаа гэж хэлмээр байна. Заримтай нь одоо ч холбоо харилцаатай байдаг. Үр ач нар минь хүртэл тэдгээр хүмүүсийн зүтгэл гавьяаг дурсаж явдаг юм.

Сурв- Та бол эрдэмтэн хүн. Одоо та ямар бүтээл дээр ажиллаж байна вэ?

Ш.А- Би Монгол Улсын өмнөд хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан хүн. Түүнээс хойш 17 жил боллоо. Миний бүтээл амьдралд хэрэгжсэн. Одоо Монгол Улсын хил хамгаалалтыг бүхэлд нь боловсронгуй болгох чиглэлээр л судалгаа шинжилгээний ажил хийж байна даа. "Монгол Улсын төрөөс хил хамгаалалтын талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр" гэсэн сэдвээр судалгааны ажил явуулаад үр дүнгий нь Хилийн Цэргийн командлалд өгсөн. Түүнд дөрөөлөн баяжуулж төрөөс баримтлах хилийн бодлогын үндэс гарах болов уу гэж найддаг. Хоёр мянга гаруй жилийн хугацаанд Монголын тусгаар тогтнолд анхаарал татаж ирсэн өмнөд хэсгийн Дорноговийн чиглэлд улсын хилийн хамгаалалт хэрхэн явж ирснийг

судалсны үндсэн дээр дэвшүүлсэн дүгнэлт, санал зөвлөмжийг дэвшүүлсэн бүтээл удахгүй хилчдийн гар дээр очно байхаа. Одоо "Монгол улсын хилийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам" гэсэн чиглэлээр судалгааны ажил хийж байна. Миний одоогийн бүтээлүүдийн үндсэн агуулга нь улсын хил хамгаалалтыг ирээдүйд боловсронгуй болгоход л туслах чиглэлтэй юм.

Сурв- Хилчид нэгийгээ егүүтгэх явдал ойр ойрхон гарч олон түмний сэтгэлийг түгшээх боллоо. Энэ хэрэг юунаас болоод байна вэ? Яаж үүнийг болиулах вэ? Таны бодол?

Ш.А. Түүхээс харахад монгол хүний хувьд ийм шившгийн явдал өдрийн од шиг ховор гарч байсан юм билээ. Өөрийгөө егүүтгэсэн хүнд оршуулгын газар олддоггүй, бусдыг егүүтгэсэн хүнд цаазнаас өөр ял байгаагүй. Ийм үйлдэл болсон газарт хэрэг хийсэн этгээдийн гэрт нь хүн орж гарахаа байж, ар гэрийнхэнтэй нь уулзахаа хүмүүс сэжиглэн цэрвэж явдаг байжээ. Тэхлээр энэ бол даанч их шившигтэй үйлдэл. Юуны урьд хэрэг хийж байгаа тухайн хүний л ухамсрын шинж, хэнтэй ч хуваалцахгүй хэнд ч хамаарахгүй үйлдэл шүү дээ. Бусдад нялзаагаад байх хэрэггүй. Тэр тусмаа зөвхөн хууль дээдэлж, хуулийн өмнө л хариуцлага хүлээх хэмжээнд нийгэм төлөвшин байгаа үед хувь хүнд өөртэй нь л хамааруулах нь зөв. Харин хойшид анхаарах сургамж авах үүднээс хэрэг гарахад нөлөөлсөн хүчин зүйлийг судлах ёстой. Юуны урьд хилчдээс хүнд нөхцөлд үүргээ гүйцэтгэхэд төрийн зүгээс бололцоо нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн эсэхийг анхаарах хэрэгтэй. Би яльгүй гэж болох тамхины тухай дээр дурдсан. Тамхи хортой, гэвч хүний хэрэглээний нэг байсаар л байна. Дэлхийд цэрэгтээ тамхины нормгүй арми монголоос өөр хаана байдгийг мэдэхгүй. Гэтэл ганц хайрцаг тамхины үнэнд хүрэхгүй шахам цалинтай цэрэгт, бүр бүгдэд нь хүрдэггүй юм бол хилийн цэрэгт ядахдаа дүнсэн тамхины норм өгч болохгүй гэж үү. Би нэгэн ноцтой хэрэг гарсан байдлыг газар дээр нь судалсан. Ердөө нэгнийгээ ганц ширхэг янжуур нууж авсан хэргээс үүдэн даамжирч эцэст нь нэгийгээ егүүтгэхэд хүрсэн байв. Өөрөөс нь өөр хүн амьтан байхгүй алс хязгаарт шөнө өдөргүй алба хааж байгаа хилчинд мөнгө байлаа ч ширхэг тамхи, ганц чихэр олоод аманд хийх боломж байдаггүй орчинд л хилчид алба хаадаг шүү дээ. Хилчин хүний эрх, эрх чөлөө хэр зэрэг баталгаатай хангагдаж байна вээ? гэдгийг ч бас төрөөс анхаарууштай. 2000 гаруй жилийн тэртээ, 800 жилийн урьд Чингис хааны үед харуулыг гурван ээлжээр, гурав хоногийн завсартайгаар ээлжлэн гүйцэтгэж байжээ. Гэтэл өнөөдөр хөрөнгө хүчний хомсдлоор шалтгаалан, өдөр шөнөгүй цөөхөн